


ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ



Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2018 онд: +3.8%, 2019 онд: +4.3%
Инфляци: 2018 онд: +8%, 2019 онд: +7%
Урсгал тэнцэл: 2018 онд ДНБ-ий -6.3%, 2019 онд: -7%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2018 он 4-р сарын тайландаа тоймлосон байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2HJFlip>


ДНБ-ий өсөлт: 2018 онд: +5%, 2019 онд: +6.3%
Инфляци: 2018 онд: +6.4%, 2019 онд: +6.8%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2018 онд: -6.4%, 2019 онд: -8.3%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2018 он 4-р сар) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 7-р сарын байдлаар 291 тэрбумын ашигтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 29.6 хувиар өсч, зарлага 6.1 хувиар өссөн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 291 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин буурсан байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 30 төгрөгөөр нэмэгдэв.

Долоодугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 53 төгрөг буюу 2.2 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 30 төгрөг буюу 1.2 хувиар нэмэгдэж 2462.83 төгрөг болов. 6-р сард гадаад валютын нөөц 2.9 тэрбум төгрөг болж өнгөрсөн сараас 8 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин буурсан байна.



Инфляцийн түвшин 7.7%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2018 оны 7-р сарын байдлаар өмнөх сараас 0.5 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар, оны эхнээс 5.5 хувь өсөв. Тус сард ингэж өсөхөд хүнсний бараа, тээврийн хэрэгсэл, түлш, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ өсөхөд нөлөөлсөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 851 сая.ам доллар болов.

2018 оны долоодугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 7382 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 26 хувиар өссөн бол экспорт 16 хувиар нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 39 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 851 сая ам.долларын ашигтай гарлаа.



7-Р САРЫН ОНЦЛОХ: ДНБ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДНБ 2018 оны 2-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 4.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 17,350 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 6.3 хувиар өсөв. ДНБ-ий 6.3 хувиар өсөхөд бүтээгдэхүүний цэвэр татвар, барилга, аж үйлдвэрийн салбар өссөн нь нөлөөлөв.

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр 8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 475.2 тэрбум төгрөгөөр өсөв. Уг өсөлтөд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 184.9 (5.8%) тэрбум төгрөг (бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртөг 73.7 тэрбум төгрөг буюу 9.0%), бүтээгдэхүүний цэвэр татвар 192.1 (21.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

ДНБ, оны үнээр 2018 оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр 15.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.1 (16.0%) их наяд төгрөгөөр өслөө. Улирлын нөлөөллийг арилган тооцсоноор ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас 1.8 хувиар өслөө.

САРЫН ОНЦЛОХ: ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ ӨСӨВ, ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ ТОГТВОРЖИВ.

- 2018 оны 7-р сарын байдлаар Монгол Улсын гадаад валютын нөөц 2017 онтой харьцуулахад 2 дахин өсч 3 тэрбум ам.доллар болов. Энэ нь 2013 оны тавдугаар сараас хойш дээд түвшинд хүрсэн нөөц бүхий үзүүлэлттэй байна. Үүнд дэлхийн зах зээл дахь эрдэс түүхий эдийн үнэ нэмэгдсэн, Оюутолгойгоос аваад уул уурхайн компаниудын хөрөнгө оруулалт нэмэгдэж, Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалт өссөн, ОУВС-гийн өргөтсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд 167 сая ам.доллар олгосон зэрэг нөлөө бий.
- 2018 оны 7-р сард Олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний “Фитч” (Fitch) агентлаг Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг “В-” байсныг “В” болгон дээшлүүлж, “Тогтвортой” төлөвт болгов. Тогтвортой болгосон шалтгаан нь “Монгол Улсын Төсвийн гүйцэтгэл, тоон үзүүлэлтүүд 2017 оны 11 дүгээр сараас хойш тогтмол сайжирч 2018 оны тавдугаар сард төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 26 хувиар өссөн. Мөн төсвийн зарлага 6 хувьд хүрсэн нь 2018 оны зорилтот түвшинд хадгалагдаж байна. Фитчийн зүгээс төсвийн алдагдал 2018 оны эцэст ДНБ-ний 3.9 хувьд хүрч бууран, улмаар Засгийн газрын нийт өр ДНБ-ийн 75.3 хувь (2017 онд 81.2 хувь, 2016 онд 91.4 хувь байсан) хүртэл буурна гэсэн төсөөлөлтэй байна. Фитч агентлагаас Монгол Улсын бодит ДНБ-ийг 2018 оны эцэст 5.2 хувь, 2019 онд 6.3 хувьд хүрэх төсөөлөлтэй байгааг мэдэгдсэн.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 7-р сар 2018 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 7-р сар 2018 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn